



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/216

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Суудлын машин, тоног төхөөрөмж /Мэргэжлийн хяналтын газар/" нийлүүлэх ажлын гүйцэтгэгч "Нам гүүр" ХХК-ийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: П.Эрдэнэчулуун – Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Гишүүд: Л.Батгэрэл – Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн


А.Жамьянсүрэн – Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин,
дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн
дарга, улсын ахлах байцаагч

Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга: Н.Баянжаргал – Мэргэжлийн хяналтын газрын нягтлан бодогч

2. "Суудлын машин, тоног төхөөрөмж /Мэргэжлийн хяналтын газар/" нийлүүлэх ажлын гүйцэтгэгч "Нам гүүр" ХХК-ийн ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /П.Эрдэнэчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Зах А/216 Чх

02 1250